



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 143

Улаанбаатар хот

Газрын тос боловсруулах үйлдвэр барих  
төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын  
талаар авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын талаар авах арга хэмжээний тухай” 21 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр” чиглэлийн төмөр замын салбар зам, хүнд даацын тусгай зориулалттай авто замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажил, барилгын ажлын техник, технологийн байнгын хяналтыг 3.5 тэрбум төгрөгийн төсөвт багтаан хэрэгжүүлэхийг “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Р.Будад даалгасугай.

2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ажлыг гүйцэтгэх ерөнхий гэрээг “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газартай зохих журмын дагуу байгуулах, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнноровт даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001705